

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Written by hanoi

Wednesday, 20 June 2018 02:24 - Last Updated Wednesday, 20 June 2018 02:26

There are no translations available.

Олон улсын хэмжээнд мордогдож буй стандартыг бүрэн хангах, монгол иргэдийн гадаадад зорчих эрхийг баталгаажуулж, гадаад улсын хилээр нэвтрэхэд тулг арч буй хвндрэлийг арилгах зорилгоор Монгол Улсын үндэсний гадаад паспортад 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн сунгалт хийхгүй болсон билээ.

Сунгалт хийлгэсэн паспорттай манай улсын иргэдийг Казахстан улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаасан тохиолдол саяхан гарсан тул сунгалттай паспортаар тус улсад зорчихгүй байхыг Гадаад харилцааны яамны Консулын газраас анхааруулж байна.

Одоо хэрэглэгдэж байгаа сунгалттай паспортын хувьд хвчинтэй хэвээр байгаа хэдий ч Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага /ИКАО/-аас сунгалттай паспортыг хэрэглээнээс халах тухай зовломжийг хэрэгжүүлж байгаа орнуудын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан үүсэх эрсдэлээс сэргийлэх үүднээс та бүхнийг цаашид шинээр паспорт захиалахыг зөвлөж байна.

Түүнчлэн гадаадад зорчиход паспортын хвчинтэй хугацаа доод тал нь 6 сар байх шаардлага тавигддаг тул паспортын хугацаа дуусах дохсон иргэдэд шинээр паспорт захиалах шаардлагатай болно.

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
КОНСУЛЫН ГАЗАР**